

Монголын материал судлал гагнуурын нийгэмлэгийн 2015 онд хийсэн ажлын тайлан

2016 оны 02 дугаар сар 01

Нэг. Монголын материал судлал гагнуурын нийгэмлэгээс тайлангийн хугацаанд хийж хэрэгжүүлэх ажлын талаар

1. ММСГН-ээс 2015 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласан.
2. Монголын металл судлал гагнуурын, нийгэмлэгийн үндсэн зорилт, үйл ажиллагаа болон нийгэмлэгээс цахилгийн хийж хэрэгжүүлэх ажлын талаар байгууллага аж ахуйн нэгж, хувь хүмүүст сурталчлан танилцуулах ажлыг байнга зохион байгуулж ажиллалаа. Нийгэмлэгийн www.mmsws.mn вебсайтыг байнга ажиллуулж байна.
3. Тус нийгэмлэгт хандаж, ажил төрлийн холбоо тогтоох, гагнуурын ИТА-ыг сургалтад хамруулах, гагнуурчдыг аттестатчилалд оруулах, гагнуур, метал судлалын чиглэлээр зөвлөгөө авах, гагнуурын ажлын чанар шалгуулах гэсэн хүсэл эрмэлзэлтэй хүмүүстэй биечлэн уулзаж, аль болох дэм тус болох чиглэлээр ажиллаж байна.
4. Эрдэс баялаг эрчим хүчиний сайдын 2010 оны 01 сарын 25-ны өдрийн 21 тоот тушаалаар батлагдсан “Гагнуурчид болон гагнуурын инженер техникийн ажилтныг мэргэшүүлж эрх олгох дүрэм”-ийн дагуу Оюу толгой ХК, Зэт Эм И ХХК, Энержи Интернейшнл ХХК, Эм Пи Ай ХХК, МегастилФабрикаторс ХХК, Эм Си Эс Интернейшнл ХХК, Рэд Паф ХХК, Эрлийн Интернейшнл ХХК, Хасумегаватт ХХК, Трансвест ХХК, Зэт Эм Стийл ХХК зэрэг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын 117 мэргэшсэн гагнуурчин болон Герман Монголын МСҮТ-ийн сургалтад хамарсан 98 гагнуурчдаас мэргэжлийн шалгалт авч гэрээндээ олгосон болно.
5. Гагнуурын үйлдвэрлэл, ажил үйлчилгээтэй холбоотой стандартыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох ажлын хүрээнд ММСГН-ээс боловсруулж батлуулсан 17 стандартыг байгууллага, аж ахуйн нэгж компанийд өгч мөрдүүлэх ажлыг энэ онд үргэлжлүүлэн зохион байгууллаа. Мен Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран “Гагнуурчны ажил мэргэжлийн лавлах” стандартыг гагнуурын мэргэжлийн б түвшнээр боловсруулан батлаж гаргасан.
6. БНХАУ-ын Шанхай хотод 2015 оны 06 сард зохион байгуулагдсан Гагнуурын олон улсын үзэсгэлэн яармагт Зэт Эм Стийл ХХК болон Оюу Толгой ХК 6 хүн, АНУ-ын Чикаго хотод 11 сард зохион байгуулагдсан Гагнуурын олон улсын үзэсгэлэн яармагт ДЦС-3 ТӨХХК, ОЧ ШИМ ХХК, ММСГН зэрэг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгуулагын гагнуурын мэргэжилтэн, гагнуурчин нийт 3 хүнийг тус

тус зуучлан зохион байгуулж, орчин үеийн гагнуурын үйлдвэрлэл, шинэ техник, технологийн ололт амжилттай таницуулсан.

7. Мэргэжлийн гагнуурчдын ур чадварын түвшинг тодорхойлох, харилцан туршлага солилицуулах зорилгоор цахилгаан, аргон, хагас автомат, хийн гагнуурын төрлөөр улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулав. Тэмцээнд 3,4-р цахилгаан станц, Дархан, Дорнод, Эрдэнэтийн ДЦС. Нийслэлийн болон Дарханы дулааны шугам сүлжээ ХК, Оюутолгой ХК, Xасу Мегаватт ХХК, Трансвест ХХК, Зэт Эм Стийл ХХК, Налайх МСҮТ, МЭЗ ХХК, СММ ХХК, ГММСҮТ, МегастилФабрикаторс ХХК зэрэг 46 үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага хувь хүн нийт 156 мэргэжлийн гагнуурчин оролцож ур чадвараа сорилоо. Тэмцээний цахилгаан гагнуурын төрөлд 31 аж ахуйн нэгж, компанийй 82 гагнуурчин оролцсоноос ГММСҮТөвийн гагнуурчин Г.Чойжамц 1-р байр, СММ ХХК-ийн гагнуурчин Б.Баттулга 2-р байр, Xасу Мегаватт ХХК-ийн гагнуурчин Б.Түвшинжаргал 3-р байр, Аргон гагнуурын төрөлд 14 аж ахуйн нэгж, компанийй 21 гагнуурчин оролцсоноос ДЦС-4 ТӨХК-ийн гагнуурчин Э.Гантулга 1-р байр, мөн ДЦС-4 ТӨХК-ийн гагнуурчин Ч.Агаандэмбэрэл 2-р байр, ГММСҮТөвийн гагнуурын багш Б.Алдарцогт 3-р байр, хагас автомат гагнуурын төрөлд 19 аж ахуйн нэгж, компанийй 40 гагнуурчин оролцсоноос ДЦС-3 ТӨХК-ийн гагнуурчин М.Ганхуяг 1-р байр, Мегастилфабрикаторс ХХК-ийн гагнуурчин С.Тэнүүн 2-р байр, мөн ДЦС-3 ТӨХК-ийн гагнуурчин К.Даваажав 3-р байр тус тус эзэлсэн. Тэмцээнд тэргүүн байр /1, 2, 3-р/ эзэлсэн гагнуурчдад мөнгөн шагнал /1000000-300000 төг/, өргөмжлөл олгосон бөгөөд байр эзэлсэн гагнуурчдад БНХАУ-ын олон улсын гагнуурын тэмцээнд оролцож эрх олгосон болно. Хийн гагнуурын төрөлд оролцсон 11 гагнуурчины сорьц стандартын шаардлага хангаагүй тул тэмцэний шалгалтын комиссын шийдвэрээр байр эзлүүлээгүй болно.
8. Герман Монголын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгт хандан гагнуурчдын сургалтын онолын хичээл заах, онолын хичээлийн хетөлбөрийг боловсронгуй болгох, гагнуурын тодорхой түвшний инженер техникийн ажилтануудыг бэлтгэх, аттестатчилах гагнуурчдаас шалгалт авах чиглэлээр ММСГН, түүний гишүүн байгууллагуудын хүрээнд ажиллах гагнуурын ажил үйлчилгээний хөгжлийн зөвлөх мэргэжилтэнийг ажиллуулах талаар албан ёсны хүсэлт тавьж шийдвэрлүүлэн 2015 оны 08-р сараас эхлэн хамтран ажиллаж байна.
9. Монгол улсын Хөдөлмөрийн Яамтай хамтран “МОНГОЛ УР ЧАДВАР – 2014” тэмцээний хүрээнд МСҮТ-д гагнуурын мэргэжлээр суралцагчдын дунд гагнуурын төрлөөр улсын аварга шалгаруулах 2 үе шаттай тэмцээнийг тус нийгэмлэгээс зохион байгуулсан бөгөөд тэмцээнд тэргүүн байр эзэлсэн Техник технологийн дээд сургуулийн Л.Ганцоож Бразил улсад зохион байгуулагдсан “ДЭЛХИЙН УР ЧАДВАР-2015” тэмцээнд Монгол улса төлөөлөн амжилттай оролцоод ирсэн. Тус тэмцээнд бэлтгэх ажлыг ДЦС-4 ТӨХК-ийн гагнуурын лабораторын эрхлэгч, ММСГНийгэмлэгийн УЗ-ийн гишүүн С.Батсайханд хариуцуулж ажилласан бөгөөд ДЦС-4 ТӨХК, Оюу Толгой ХК, Зэт Эм Стийл ХХК,

ГММСҮТөв зэрэг байгууллагуудын үйлдвэр болон сургалтын баазуудад төлөвлөгөөний дагуу байнгын бэлтгэл ~~хийсэн~~.

10. Азийн гагнуурын холбоо (АГХ)-ноос тус холбооны гишүүн улсуудын хүрээнд Гагнуурчдыг аттестатчилах ерөнхий тогтолцоо буй болгох талаар ажиллаж байна. Энэ чиглэлээр АГХ-ны ажлын хэсгүүд 3 дүрэм, 23 үйл ажиллагааны журам боловсруулан АГХ-ны удирдах зөвлөлөөр баталж гаргасан . Одоогоор энэхүү ГАЕТ-г хэрэгжүүлэх үйл ~~ажиллагаа~~ явагдаж эхлээд байна. Манай ММСГН-ийн хувьд түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. Тус нийгэмлэгээс дээр дурьдсан дүрэм журмуудыг англиас монгол болгон бүрэн орчуулж холбогдох хүмүүст товч танилцуулсан. ГАЕТ-ы талаар танилцуулгыг нийгэмлэгээс „Эрчим хүч инженеринг“, сэтгүүлд тавьж нийтлүүллээ
11. Азийн гагнуурын холбоо (АГХ)-ны зохион байгуулж буй ажилд гишүүн байгууллагын хувьд байнга оролцож ~~байна~~.
а/ Тайланд хотод 2015 оны 4 сард зохион байгуулагдсан Азийн гагнуурын холбооны Удирдах зөвлөлийн 23-р хурал, ажлын хэсгийн 15-р хуралдаанд нийгэмлэгийн УЗ-ийн гишүүн Зэт Эм И ХХК-ийн захирал Б.Зулбаяр оролцсон. Энэ хуралд Япон, Индонез, Хятад, ~~Мянмар~~, Филиппин, Тайланд, Сингапур, Малайз, Монгол, Солонгос зэрэг 10 улс хүрэлцэж ирсэн. Дээрх хурлуудаар ажлын хэсгүүдийн хуралдааны ~~тайлан~~, стандартчиллын асуудал, АГХ-ны вебсайт, АГХ-ны гишүүнчлэлийн ~~асуудал~~, АГХ-ны гишүүн улсуудын ГАЕТ, АХБТ-г хэрэгжүүлэх төлөвлөгөө, хэрэгжилтийн явц, АГХ болон Америкийн гагнуурын нийгэмлэг, түүний ASME тогтолцоотой холбоотой ярилцлагын дүн, АГХ-ны нарийн бичгийн дарга нарын ~~ажил~~ үйлчилгээ, АГХ-ны дүрмийн зарим өөрчлөлт засварын тухай зэрэг асуудлыг хэлэлцсэн.
б/АГХ-оос ажил төрлийн шугамаар ~~и~~рүүлсэн санал асуулгад цаг тухайд нь саналаа хүргүүлж хамтран ажиллаж ~~байна~~.
12. Тус нийгэмлэгт хандаж, ажил төрлийн холбоо тогтоох, гагнуурын ИТА-ыг сургалтад хамруулах, гагнуурчдыг аттестатчилалд оруулах, гагнуур, метал судалын чиглэлээр зөвлөгөө авах, гагнуурын ажлын чанар шалгуулах гэсэн хүсэл эрмэлзэлтэй хүмүүстэй биечлэн уулзаж, аль болох дэм тус болох чиглэлээр ажиллаж байна.
13. Нийгэмлэгийн гишүүнчлэлийн ~~хураамж~~ цуглуулах тал дээр нилээн чармайлт гаргаж 10 гаруй компани захиралтай биечлэн уулзаж ажлаа сурталчилж ажилласнаар татварын орлого эрс дээшилсэн
14. ММСГН-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж шинчлэн батлуулж Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлсэн.
15. ММСГН-ийн гүйцэтгэх захирал Г.Доржийн ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн авч УЗ хэлэлцэн ажлаас нь чөлөөлж Н.Мягмарсүрэнг гүйцэтгэх захиралаар томилсон.

16. ММСГН-ийн ажлын 2014 оны тайланг Улсын бүртгэлийн газарт хугацаанд нь өгсөн.
17. ММСГН өөрийн санхүүгийн тайлан, татварын тайлан, нийгмийн даатгалын тайланг улирал, сар бүрээр гаргаж тооцоогоо хийж байна. Татварын тайланг цахим хэлбэрээр тоон гарын үсгээр өгч байна.
18. Нийгэмлэгийн тэргүүн А.Тлейхан, УИХ-ын гишүүн, СБД 3-р хороо, 5-р хороолол, 17-р байр, 8 тоот, гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн БГД 6-р хороо 10-р хороолол. ХД 58-р байр. 01 тоот, ерөнхий зохицуулагч Ц.Шүрэнцэцэг СХД 32-р хороо Москва хороолол 1-12 тоот, Д.Нямсүрэн БГД 15-р хороо, 3-р хороолол 23а -34 тоот, удирдах зөвлөлийн гишүүн Ж.Түмэн-Аюуш ХУД 11-р хороо 2-р хэсэг, Лагшири зaisan вилаж 5-р байр 5 тоот, Б.Зулбаяр ЧД 5-р хороо, 6-р хороолол 9-54 тоот, С.Батсайхан БГД 12-р хороо, 4-р хороолол 20-144 тоот, Д.Эрдэнэ-Очир БЗД 12-р хороо, Дүнжингарав хороолол 107-8 тоот, Ариунсан Эрдэнэтийн УБҮ ЗМҮ, Л.Энхбаяр, Ч.Анхаа

Хоёр. Нийгэмлэгийн ажилд өршилж буй дутагдал доголдол.

1. Үйлдвэрлэл, аж ахуйн зарим салбарын хүрээнд гагнуурын ажлын стандарт, шаардлагыг мөрдүүлэх ажил хийгдэхгүй байна. Энэ нь салбар, аж ахуйн нэгж, байгууллага, компаний удирдлага нь гагнуурын ажил үйлчилгээний мөн чанар, түүний стандарт, шаардлагын талаар ошголт муутай, олон улсын жишгээс хол, гагнуурын ажлын чанар нь зөвхөн үнэмлэхтэй, үнэмлэхгүй гагнуурчнаас л хамаарах юм шиг өрөөсгөл ойлголтоос салж чадаагүйтэй холбоотой. Олон улсын хэмжээнд гагнуурчдыг аттестатчилах нийтлэг тогтолцоотой болчихоод байхад манай улсын хувьд үйлдвэрлэл аж ахуйн зарим салбарын хүрээнд нэгдсэн ойлголтод хүрч чадахгүй байсаар байгаад ММСГН дүгнэлт хийж ажиллах ёстой бөгөөд энэ талаар хангальгүй ажиллаж байна.
2. АГХ-ны санал болгож буй гагнуурчдын ур чадварын бүртгэлийн тогтолцоо /MOS/- г ММСГН, түүний зарим гишүүн байгууллагын хүрээнд нэвтрүүлэх ажилд ахиц гарсангүй.
3. АГХ-ны гишүүн улсын хувиар АГХ-ны гагнуурчдыг мэргэшүүлж эрх олгох шинэ тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хүрээнд гагнуурын инженер техникийн ажилтан, гагнуурын багш нарын мэдлэг, ур чадвар шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.
4. Гагнуурчдын аттестатчилал зохион байгуулж, шалгалт авах эрх бүхий ажилтаныг сургаж бэлтгэх, тэднийг батлагаажуулж эрх олгох ажил хийгдэхгүй байна
5. Материал судлалын чиглэлээр тодорхой ажил хийгдэхгүй байна.
6. Гишүүн байгууллагуудыг гагнуурын техникийн дэвшил арга барил ололт зэрэг мэдээллээр хангаж чадахгүй байна

Гурав. Нийгэмлэгийн зүгээс цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар

Монгол улсын хэмжээнд гагнуурын ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, нийгэмлэгийн ажлыг уlam боловсронгуй болгох зорилгоор ММСГН- ээс 2016 онд дараах ажлыг хийж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Гагнуурын ажил үйлчилгээ явуулдаг байгууллага, гагнуурын мэргэжлийн хүмүүст ММСГН-ийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг байнга зохион байгуулах, нийгэмлэгийн эгнээг өргөтгэж, гагнуурын ажил үйлчилгээг хөгжүүлэх үйлсэд цаашид хамтран ажиллах.
2. Мэргэшлийн гагнуурчид болон гагнуурын мэргэжлийн инженер техникийн ажилтныг мэргэшүүлж эрх олгох ажлыг 2010 онд батлагдсан “Гагнуурчид болон гагнуурын инженер техникийн ажилтныг мэргэшүүлж эрх олгох дурэм” –ийн дагуу зохион байгуулж ажиллах, дүрэмд засны дагуу мэргэшлийн гагнуурчдын улсын хэмжээний бүртгэлийг байнга хийж байх
3. АГХ-ны гагнуурчдыг мэргэшүүлж эрх олгох шинэ тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хүрээнд гагнуурчдыг аттестатчлах албан ёсны эрх бүхий байгууллага, итгэмжлэл бүхий шалгалтын төв, сургалт явуулах эрх бүхий байгууллага, хяналт шалгалтын ажилтан, шалгах ажилтантай болох ажлыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах
4. Гагнуурчдын аттестатчилал зохион байгуулж, шалгalt авах эрх бүхий ажилтаныг сургаж бэлтгэх, тэднийг батлагаажуулж эрх олгох мөн гагнуурын инженер техникийн ажилтны мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах
5. БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулагдах олон улсын гагнуурын тэмцээнд оролдох монголын гагнуурчдыг нэгдсэн бэлтгэлд хамрагдуулж хобогдох бичиг баримтыг бүрдүүлж зохион байгуулах
6. Гагнуурчдын мэдлэг, ур чадварыг дээшүүлэхэд чиглэсэн арга хэмжээ тухайлбал гагнуурчид бэлтгэх сургалтын чанар, гагнуурын багш нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор багш нарыг сургах, аттестатчилал ажилд нийгэмлэгийн зүгээс онцгой анхаарал тавьж ажиллах
7. АГХ-ны хүрээнд гагнуурчдыг мэргэшүүлж эрх олгох шинэ тогтолцоог хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж ажиллах, энэ тогтолцоонд шилжих үеийн бэлтгэл ажлыг зохион байгуулах, АГХ-ы аудитортой болох арга хэмжээ авах
8. Гагнуурын инженер техникийн ажилтнуудыг мэргэшүүлж эрх олгохтой холбогдсон сургалтыг аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр зохион байгуулж ажиллах.
9. 2016 онд гадаад орнуудад метал судалал, гагнуурын чиглэлээр олон улсын хэмжээнд зохион байгуулагдах үйл ажиллагааны талаар үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад мэдээлгүүд сургалтуухаа тайлбарийг зуулсан срэгийн тайлбарыг яриадаа бийрүүлж.

10. Азийн гагнуурын холбооны ээлжит хурал болон тус холбооноос зохион байгуулж буй бүх төрлийн ажилд илэвхтэй оролцож байх, гагнуурын олон улсын институттай харилцаа тогтоох, улмаар гагнуурын чиглэлийн стандарт техникийн баримт бичиг боловсруулах, боловсронгуй болгох үйл ажиллагаанд оролцох
11. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад гагнуурын ажил үйлчилгээний стандарт, норм дүрмийн шаардлагыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх, гагнуурын технологи боловсруулах, гагнуурчдыг шалгаж эрх олгох, гагнаасны чанарыг шалгах, гагнуурын ажлын холбогдох баримт бичгийг бүрдүүлэх зэрэг ажилд туслах.
12. MNS ИСО 3834:2010 “Металд хайлуулах аргаар гагнуур хийх үеийн чанарын шаардлага” гэсэн цуврал стандартыг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдүүлж хэрэгжүүлэхэд туслахаа үзүүлэх.

Тайлан бичсэн:

Ерөнхий зохицуулагч

Ц.Шүрэнцэцэг